



ТӨВ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА

41100 Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272038

СУМЫН ЗАСАГ ДАРГА, ТӨСӨВТ
БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА НАРТ

2022.06.27 № 33/47
танай _____-ны № _____-Т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Сум, байгууллагын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэхтэй холбоотой хөрөнгийн эх үүсвэр бий болгох, хандив тусламж хүсэх, авч болох эсэх хуулийн зохицуулалтын талаарх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Монгол улсын Төсвийн тухай хуулийн 18.1-д “Төрийн болон орон нутгийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгай сангаар дамжуулан гүйцэтгэж болно”, 18.2-т “Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна” гэж хуульчилж заасан байна. Орон нутагт Засаг даргын нөөц сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан гэж байгаа бөгөөд эдгээр сангууд нь төсвийн эх үүсвэрээр бий болсон сан юм. Мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гээд зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллагууд хандив, тусламж авч болохоор заасан бөгөөд 25.6-д “Тусламжийн орлогоос санхүүжүүлэхэд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэгэн адил баримтална”, 25.7-д “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана” гэж заасан нь аливаа хандив, тусламж нь Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар тайлан тэнцэлд тусгагдахаар байна.
2. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь энэ хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий Төсвийн тухай хуульд зааснаас өөр бусад сантай байж болно. Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна”, 17.2-т “Энэ хуулийн 17.1-д заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг тухайн шатны Хурал тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасан байна. Монгол улсын Дээд шүүхийн тайлбарт “Энэ зүйлд зааснаар ийм сангийн хөрөнгийг гагцхүү **нэгжийн чиг үүргийг** хэрэгжүүлэхэд дэмжлэг болох үүднээс зарцуулах ёстой. Сангийн зарцуулалтыг хянах явцад нэгжийн чиг үүрэгт хамаарахгүй зүйлд хөрөнгө

зарцуулсан байвал буруутай этгээдээр буцаан төлүүлэх эрх зүйн үр дагавар үүснэ” гэж тайлбарласан байна.

Монгол улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1-д “**Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно**, 17.2-т “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно” гэж заасан бөгөөд тэмдэглэлт ой, баяр наадамд зориулж хандив, тусламж хүсэх, авах талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Иймд сум, байгууллагын ойг тэмдэглэх ажлын хүрээнд баяр наадам зохион байгуулахтай холбоотойгоор иргэд болон аж ахуйн нэгж байгууллагаас **өөрсдийн санал санаачлагаар хандив тусламж өгье гэж байгаа** бол түүнийг хүлээн авах ажлыг баяр наадмыг зохион байгуулах нутгийн зөвлөл болон төрийн бус байгууллагаар дамжуулж зохион байгуулах нь зүйтэй. Энэ үйл ажиллагаанд төрийн байгууллага, албан хаагчид оролцохыг хориглосон байна.

ДАРГА



Б.САРУУЛ